



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 дугаар сарын 13 өдөр Дугаар 25

Хэрлэн сум

XXV ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын өргөтгөсөн хурал 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 14:30 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 97 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж, холбогдох үүрэг даалгаврын өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Улсын Онцгой комиссоос ирүүлсэн албан бичгүүдийг хэлэлцэх: Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газар,

2. Улсын Онцгой комиссын шийдвэрээр аймгийн Онцгой комисст даалгасан үүрэг даалгавруудын хэрэгжилтийн тайланг хэлэлцэж, хүргүүлэх: Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар,

3. Дараагийн хуралдаанд аймгийн Онцгой комиссын өмнөх хуралдаануудаас сум, байгууллага, албан тушаалтнуудад өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн тайланг урьдчилан ирүүлэхийг даалгах: Аймгийн Засаг дарга,

4. Аймгийн төв болон сумын төвийн гудамж, талбайд нийтийн эргүүл ажиллуулах тухай: Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар,

5. Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр "Петро Чайна Дачин Тамсаг" ХХК-д 2020 оны 03 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд ажилласан ажлын хэсгийн зардал болох 1,404,740 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас шийдвэрлүүлэх тухай: Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,

ТАНИЛЦУУЛСАН НЬ:

1. Ариутгал, халдваргүйтгэлийн ажлын явцын талаар: /Хэрлэн сумын Засаг даргын орлогч О.Пүрэв-Очир/,

2.Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд олон нийтийн худалдаа үйлчилгээ, төрийн байгууллагуудаар үйлчлүүлэхдээ заавал амны хаалт зүүсэн байх тухай шийдвэрийн төсөл танилцуулах: /Эрүүл мэндийн газрын дарга Ч.Оюунаа/,

3.Цэрэг татлагын ажил зохион байгуулах талаар: /Цэргийн штабын дарга дэд хурандаа О.Ганзориг/,

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.1.Улсын Онцгой комиссын шийдвэрээр аймгийн Онцгой комисст даалгасан үүрэг даалгавруудын хэрэгжилтийн тайланг мэргэжлийн байгууллагуудаас авч нэгтгэн Улсын Онцгой комисст хугацаанд нь хүргүүлэхийг,

1.2.Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэн тус бүрт нэг ширхэг амны даавуун хаалтыг аймгийн Амны хаалтын нөөцөөс олгохыг,

1.3.Аймгийн нөөц бүрдүүлэх 15,000 ширхэг амны хаалтыг оёх зардал, нийтийн эргүүлд томилогдож ажиллах албан хаагч нарт амны хаалт, шатахуун, ханцуйн тэмдэг хийлгэх зардлыг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас олгохыг,

Хоёр. Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн А.Нансалмаа-д:

2.1.Нийтийн эргүүлийг зохион байгуулах тухай удирдамж, хуваарь, эргүүлд гарах алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах амны хаалт, гар ариутгагч, шатахуун, ханцуйн тэмдэг хийх зардлын тооцоог гаргаж танилцуулахыг,

Гурав. Аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн-д,

3.1.Нутаг дэвсгэрийн хэмжээнд Улсын Онцгой комиссын 2020 оны 9 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн болон хувийн хэвшлийн нийт байгууллагууд, иргэдэд амны хаалттай үйлчлэх, амны хаалтны хэрэгжилтийг нийт иргэдэд хуулийн дагуу үүрэг болгох тухай эрх зүйн акт гаргахыг,

Дөрөв.Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат-д:

4.1.Бүх нийтийн цэвэрлэгээний тухай сумдын мэдээг нэгтгэж, дараагийн Онцгой комиссын хуралд танилцуулах, сумдын Засаг дарга нарт аймгийн Засаг даргын 2020 оны "Цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажил зохион байгуулах тухай" А/180 дугаар захирамжийг албан бичгээр хүргүүлэхийг,

4.2.Хөрш зэргэлдээ улсуудад Коронавируст (COVID-19) халдварт өвчин гарсантай холбогдуулан хилийн анги нэгтгэлүүдийн дарга, захирагч нарт хилийн уулзалтыг биечлэн зохион байгуулахгүй байх тухай албан бичгийг хүргүүлэхийг,

Тав. АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

5.1.Гэр хорооллын хог, хаягдлыг цэвэрлэх ажлыг нэгдсэн журмаар зохион байгуулах, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудыг татан оролцуулах, шаардагдах зардлын тооцоог гаргаж танилцуулахыг,

Зургаа.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа-д:

6.1.Газрын тос тээвэрлэлт Улсын онцгой комиссын шийдвэрээр эхэлсэн. Аймгийн Онцгой комиссоос “Петро Чайна Дачин Тамсаг” ХХК-д хүргүүлсэн 7 төрлийн заалт бүхий албан бичгийг Хилийн анги нэгтгэлүүд, Гадаадын харьяатын Зүүн бүс дэх газар, Гаалийн газар зэрэг байгууллагад хувилж хүргүүлэхийг.

Долоо. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий-д:

7.1.Цэрэг татлагын үеэр иргэдийн бөөгнөрөл үүсгэхгүй байх тухай иргэд, олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүргэх, сумдын Засаг дарга нарт албан бичгээр хүргүүлж үүрэгжүүлэхийг,

Найм.Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ж.Алимаа-д:

8.1.Иргэд, олон нийтэд ноолуурын худалдан авалтын тухай мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шуурхай хүргэхийг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА

